

НЭГДСЭН ГЕРМАН УЛС БАЙГУУЛАГДСАНЫ ДАРААХИ ҮЕИЙН ГЕРМАНЫ ГАДААД БОДЛОГЫН ШИНЭЛЭГ ЧАНАРУУД

*Р. Жамц**

1990 он хүртэлхи ХБНГУ-ын гадаад бодлого нь өөрийн өвөрмөц онцлогтой байсан бөгөөд нэгдсэн Герман улс байгуулагдсаны дараахь үеийн Германы гадаад бодлого ч өөрийн шинэлэг чанартай нь тодорхой болж байна. 1930-аад онуудад Герман улсад бүрэлдсэн харгис дэглэмээс өдөөсөн дэлхийн II дайны дараа хоёр туйлт дэлхийн систем бүрэлдэн тогтож, Герман үндэстний нэгдмэл улс хуваагдан, хоёр улс байгуулагдаж, эсрэг тэсрэг хоёр системд хамрагдах болсон билээ. Хоёр туйлын хилийн шугам нь Германы нутгаар нэвтрэн өнгөрч 1990 он хүртэл даруй 45 жилийн турш бэхжин тогтсон түүхтэй. XX зууны хоёрдугаар хагасын гадаад бодлого энэ хилээр тодорхойлогдож, чухамдаа Өрнө-Дорнын эсрэг тэсрэг сөргөлдөөн дэлхийн хэмжээнд үйлчилж байсан юм. Энэ үеийн гадаад бодлого нь өөрийн системийн нөлөөг өргөтгөж, өрсөлдөгчийнхийг шахан зайлуулахад чиглэж байжээ. Дайны дараа ХБНГУ олон улсын тавцан дээр гол тоглогч байгаагүй билээ. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш хязгаарлагдмал бүрэн эрхтэй байсан ХБНГУ эдийн засгийн хувьд үлэмж, харин улс төрийн хувьд бичил биетэй байсан юм. Энэ тухай Хенри Киссинжир Герман улс бол “орших, эс орших замаа хайж буй эдийн засаг мөн” хэмээн тэмдэглэж байсан удаатай. Хүйтэн дайны үед тус улсын гадаад бодлого юун түрүүн аюулгүй байдал, батлан хамгаалах болон хуваагдмал орон байсны хувьд Германы асуудал гэсэн бодлогоор тодорхойлогдож байлаа.

Энэ үед ойрхон гишгэж, намуухан дуугарах нь Германы гадаад бодлогын арга барилыг илэрхийлэн, энэ байдлаараа тус улс удаан хугацаанд амжилттай явж, аюулгүй байдлаа хамгаалан, эдийн засгаа сэргээн хөгжүүлж, тавьсан зорилгоо үр ашигтай хэрэгжүүлж ирсэн гэж Германы зарим судлаачид үздэг. Энэ бүхэн дайны дараахь үеийн Германы гадаад бодлогын нэг онцлог гэж үзэж болох талтай.

1990 онд Герман улс дахин нэгдэж бүрэн эрхт байдлаа бүрэн утгаар нь эргүүлж авснаар уг дүр төрх үндсэндээ өөрчлөгдсөн билээ. Чухам энэ үеэс эхлэн Германы улс төрийн нэр нөлөө улам нэмэгдсэн билээ. Хүн амын тоо, эдийн засгийн хүчин чадал, геополитикийн байршил болоод ашиг сонирхлынхоо хувьд Герман улс одоо олон улсын

Р.Жамц - эдийн засгийн ухааны доктор

тавцан дээр чухал тоглогчийн тоонд ороод байна. Ийнхүү улс төрийн эрх мэдэл, нөлөө эргэлзээгүй өсөн нэмэгдэн, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник технологи, мэдээллийн системийн талаар өндөр хөгжилд хүрсэн Герман улс чухам ямар чиглэл зорилттой гадаад бодлого явуулах бол гэж дэлхийн олон улс анхааралтай харах болсон билээ. Ямар ч гэсэн ХБНГУ-ын өнгөрсөн 10 гаруй жилийн үйл явцаас үзэхэд түүхийн хариуцлагатай үед Герман улс бие даасан, тодорхой чиглэлтэй, өнөөгийн дэлхий дахины байдалд бодитой дүгнэлт хийсэн ухаалаг гадаад бодлого явуулж эхэллээ гэсэн дүгнэлт хийж болох талтай гэж судлаачийн хувьд дүгнэж байна. Одоохондоо Германы гадаад бодлогын шинэ чиг хандлагын өрнөл дуусаагүй байна. Гэхдээ гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын дүгнэлт, Германы гадаад бодлогын өрнөлтийн явцаас үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

1. ХБНГУ нь одоогийн дэлхийд эзлэх болсон байр суурьдаа нухацтай дүгнэлт хийж, ХБНГУ олон улсын бодлогыг зөвхөн тээгч, хэрэглэгч биш бас бүтээгчийн нэг болсонд онцгой хариуцлагатай хандаж ухаалаг гадаад бодлого өрнүүлж эхэллээ.
2. ХБНГУ, дэлхийн олон нийт ч ХБНГУ-ын энэхүү гадаад бодлогын эхлэлд талархан хандаж байна. Үүний нэг илрэл нь ХБНГУ-ыг НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын бус гишүүнээр 2002 онд сонгосон явдал юм. ХБНГУ дэлхийн хэмжээнд гадаад бодлогынхоо шинэ чиг бодлогыг тодорхойлохдоо өнөөгийн шинэ нөхцөлд аюулгүй байдлын асуудал түүнчлэн дэлхий даяар өрнөж буй даяарчлалын үр дагаврын асуудлыг ул суурьтай харгалзаж үзэх бололтой. Өнөөдөр дэлхийд нэг туйлт систем тогтнож, тоталитаризм нурсан ч ардчилал бүрэн дүүрэн ялж чадаагүй байна. Угсаатны болоод салан тусгаарлах тэмцлүүд дэлхийн хэмжээгээр нэмэгдсээр байна. Олон улсын гэмт хэрэг, шашны фундаменталист үзэл болон хэт үндсэрхэг үзлээс сэдэвтэй террорист ажиллагаа цоо шинэ аюулыг бий болгож байна. Дээр дурдсанчилан олон талын учир шалтгаанаар үүссэн жижиг мөргөлдөөн зөрчлүүд орчин үеийн гадаад бодлогод шинэ шаардлагыг тавьж байна гэж ХБНГУ үзэж байгаа бололтой. Аюулгүй байдлын ийм шинэ эрсдэлүүдийн зэрэгцээ даяарчлалын үр дагавар ХБНГУ-ын гадаад бодлогын гол цөмийн нэг болоод байгаа мэт. Дэлхий даяар даяарчлалын үйл явц бодит зүйл болоод байна. Ийм нөхцөлд хэрхэн зохицож гадаад бодлого явуулах, улс орныхоо аюулгүй байдал, соёл иргэншлээ хадгалж

үлдэх асуудал зөвхөн ХБНГУ-ын хувьд биш бүх орнуудын хувьд гол асуудал болоод байна.

3. Гадаад бодлогын залгамж чанар нь Германы гадаад бодлогыг өөрийн зорилго болгон хувиргах ёсгүй. Шинэ санаачлагыг үл ойшоон шаардлагатай шинэчлэлийг сааруулах л юм бол тэр залгамж чанар саад тотгор болж эхэлнэ гэж ХБНГУ үзэж буй бололтой. XXI зууны Германы гадаад бодлогод Европын интеграци АНУ-тай харилцах харилцаа болон НАТО-ийн хэтийн төлөв, түүнчлэн ОХУ, Хятадын харилцааны хөгжлийн асуудлууд чухал байр эзлэх бололтой. ХБНГУ-ын хүчин чармайлтаар Европын Холбоо үүсч эрчимтэй хөгжиж байна. Европын интеграцийг бүрэн хэрэгжүүлэх явдал Европыг улам нягтруулж хүчин чадлыг нийлүүлэн олон улсын тавцан дээр Европын Холбооны нэрээр ярилцах болсон нь чухал үр дүнгээ өгч, түүхийн олон удаагийн гашуун сургамжийн дараагаар хагарч бутарсан байсан Европын энх тайвны жинхэнэ нэгдлийг бий болгож чадлаа гэж ХБНГУ-д үзэж байгаа бололтой.
4. ХБНГУ өөрийн гэсэн өнгө аястай, бие даасан гадаад бодлого явуулж эхэллээ. Үүний нэг жишээ нь Иракийн асуудлаар АНУ-аас өөр, асуудлыг дипломат шугамаар НҮБ-ын шийдвэрийг хүндэтгэн шийдэх ёстой гэсэн санал тавьсан явдал юм. Түүнчлэн сүүлийн арван жилд Герман улс олон улсын түвшинд хямралыг зохицуулах ажиллагаанд, өөрөөр хэлбэл, энхийг сахиулах ажилд улам бүр идэвхтэй оролцож ирлээ. Үүнд Косово, Афганистан зэрэг улсуудад энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд ХБНГУ тодорхой хэмжээний цэргээ оруулсан явдал юм.
5. ХБНГУ дэлхий даяар явуулах гадаад бодлогын үзэл баримтлалаа боловсруулж эхлээд байна. Үүний нэг жишээ нь Канцлер асан Хельмут Колийн Засгийн газрын үед 1993 оны 9-р сард Азийн орнуудын талаархи үзэл баримтлалыг боловсруулж, түүгээрээ Ази-Номхон далайн бүс нутгаас эдийн засгийн хөгжилд идэвхтэй нөлөөлөх шаардлага байгааг тодорхой харуулсан бол 2002 онд Шрёдерийн засгийн газар Зүүн хойт Ази, Төв Ази, Зүүн өмнөд Азид явуулах гадаад бодлогынхоо үзэл баримтлалыг шинээр батлан гаргалаа.

**ХБНГУ-аас Монгол Улсын талаар явуулах болсон
гадаад бодлогын зэрэг шинжүүд, хэтийн төлөв**

Хоёр Герман улс нэгдсэн түүхэн үйл явдлын дараа ч ХБНГУ нь Монгол-Германы харилцааг түүхэн шинэ нөхцөл байдалд нийцүүлэн идэвхтэй хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж, ардчиллын замаар хөгжин зах зээлийн эдийн засаг бодлого хэрэгжүүлэн олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого явуулах болсон Монгол улсыг эхнээс нь идэвхтэй дэмжсэн юм. Чингэхдээ хуучин БНАГУ-тай харилцаж, хамтран ажиллаж байсан үеийн үнэ цэнэтэй, нааштай бүхнийг өвлөн авч шинэхэн үеийн харилцааныхаа бодит хүчин зүйл болгон хөгжүүлж чадсан билээ.

Монголоос Зүүн Германд тэдний Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байсан 500 гаруй оюутан, сурагчдыг үргэлжлүүлэн сургаж, төгсгөснөөс гадна малын хортон шимэгчтэй тэмцэх арга хэмжээ зэрэг уламжлалт төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Хөгжлийн зориулалттай зээл тусламж олгож эхэлсэн бөгөөд эхэн үедээ Бороогийн алтны орд газар, Борнуурын САА зэрэг объектууд дээр анхаарч байснаа эрчим хүч, харилцаа холбоо, байгаль орчин, эрх зүйн шинэчлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг шинэ салбар уруу орсон билээ.

Өнгөрсөн 10-аад жилд ХБНГУ-аас Монголд үзүүлсэн зээл тусламж тасралтгүй өсч, нэмэгдсэн билээ. Монгол улс ХБНГУ-ын хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хүрээнд ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш нийт 379 сая дойч марк /ДМ/-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг авсанаас 168 сая нь санхүүгийн хамтын ажиллагааны, 79 сая нь хамтын ажиллагааны бусад хэлбэрийн тусламж байв.

ХБНГУ-ын Монгол Улстай эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарт төдийгүй нийгмийн амьдралын бүх салбарт харилцаагаа өргөжүүлж байна. Барууны тэргүүний хөгжилтэй ардчилсан орнууд, ялангуяа Их-7 хэмээн нэрлэгддэг байсан орнуудаас төрийн тэргүүн нь Монголд айлчилсан, харилцааны тулгуур баримт бичиг байгуулсан анхны орон бол Герман бөгөөд эдгээр үйл явдал нь хоёр талын харилцааны хувьд чухал байсан төдийгүй Монголын олон улсын нэр хүндийг цаашид дээшлүүлэхэд үзүүлсэн томоохон дэмжлэг гэж үзэх ёстой юм.

1990 оноос Нэгдсэн Герман Монгол Улсын хоорондын харилцааг хөгжүүлэхэд улс төр, үзэл суртлын ямар ч хаалт хязгаарлалт байхгүй болж, өнгөрсөн 10-аад жилийн хугацаанд, 1995 онд Монгол Улсын анхны ерөнхийлөгч ХБНГУ-д айлчилсан билээ. Үүний хариуд 1998 онд Холбооны Ерөнхийлөгч асан Роман Херцог Монголд айлчилсан. 2000 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Багабанди Германд айлчилсан юм. 2002 онд Монгол Улсын Ерөнхий сайд Н. Энхбаяр нар Германд айлчилсан билээ.

Парламентийн түвшинд ч тэр Парламентын дарга, дэд дарга, байнгын хороод, Парламентын бүлэг болон гишүүдийн ганцаарчилсан айлчлал болж буй нь харилцан санаа бодлоо солилцох боломжийг бүрдүүлж байна. Хоёр орны яамдууд нягт хамтран ажиллаж, эдийн засаг, эрх зүй, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, батлан хамгаалах, төрийн захиргаа зэрэг олон салбарт, төрөл бүрийн хөтөлбөр төслийг хэрэгжүүлж байна. Монгол, Германы харилцаанд оролцогчдын тоо нэмэгдэж, Засгийн газар, Парламентын хүрээнээс халин олон нийтийн байгууллага, муж улс, улс төрийн сангуудыг хамран амжилттай хөгжих болсон билээ.

Монгол-Германы харилцааны түвшин байнга өсч байна. Хоёр талын харилцааг ХБНГУ-ын дэд канцлер, Гадаад хэргийн сайд К. Кинкель 1996 онд Монголд айлчлах үеэрээ “идэвхтэй, сайн харилцаа” гэж үнэлээд “ХБНГУ-ын Азийн бодлогын үзэл баримтлалд Монгол Улс өөрийн гэсэн байр суурьтай” хэмээн мэдэгдэж байсан бол 1998 онд Холбооны Ерөнхийлөгч Р. Херцог “Герман-Монголын харилцаа бол онцгой итгэмжилсэн харилцаа” хэмээн өндөр үнэлэн дүгнэсэн нь энэ үеийн харилцааны түвшин, шинж чанарыг бэлхэнээ тодорхойлсон хэрэг юм. Өнөө үед ХБНГУ Ази тивийн улс орнуудтай харилцах талаар гадаад бодлогынхоо үзэл баримтлалыг боловсруулж хэрэгжүүлэх боллоо.

2002 онд Канцлер Шрёдерийн Засгийн газрын боловсруулсан Зүүн Хойт Азид явуулах Германы гадаад бодлогын зорилтууддаа Германы гадаад бодлогын үндсэн зарчмуудын үндсэн дээр Германы Зүүн Азийн бодлого нь Германы болон Зүүн Азийн Хөгжлийн явцтай нийцэж байхын зэрэгцээ тухайн улс орон, тухайн нөхцөл байдал бүрийн шаардлагад тохирч харилцан адилгүйгээр тодорхойлогдсон байх болно гэсэн билээ. Үүнээс гадна Германы Зүүн Азийн бодлого нь Европын Холбооны интеграцчиллын хүрээнд Атлантын болон Их-Наймын түншүүдтэйгээ нэгдсэн байр суурийг баримтлахад анхаарах болно гээд

Япон, Өмнөд Солонгос, Монгол нь ардчилсан улсууд юм. Орос, Хятадын дунд “сандвич” шиг геополитикийн байрлалтай, ардчилсан Монгол улсыг бие даасан гадаад бодлого явуулахад нь дэмжлэг үзүүлнэ гэж зориуд тэмдэглэжээ. Энэ бүхнээс үзэхэд Монгол-Германы харилцаа идэвхтэй хөгжих сайхан ирээдүй харагдаж байна.